



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2021.10.28 № 3/1809
танай _____-ны № _____-т

АЙМАГ (НИЙСЛЭЛ), ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
(ГАЗАР)-ИЙН ДАРГА НАРТ

Шийдвэр хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт даатгуулагчийн 1995 оноос өмнөх үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд ажил, мэргэжлийн жишиг цалинд үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлж болно гэж заасан.

Хуулийн энэхүү заалтын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн А/136 дугаар тушаалаар “Ажил мэргэжлийн жишиг цалингийн хэмжээ”-г шинэчлэн баталж, уг тушаалын 2-т заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/132 тушаалаар баталсан “Ажил, мэргэжлийн жишиг цалинг үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлоход баримтлах журам”-ыг хүргүүлж байна.

Иймд даатгуулагч, тэтгэвэр авагч, иргэдэд эдгээр тушаал, журмын талаар мэдээлэл хүргэн, байцаагч, ажилтнуудыг мэргэжил арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг зөвлөж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн “Ажил мэргэжлийн жишиг цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” А/136 тоот тушаалын хуулбарыг хавсаргав.

Хавсралт 2 хуудастай.

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН
ДАРГА



Ц.ГАНЦЭЦЭГ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/132

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 4, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм”-ийн 3.2.4, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны “Ажил, мэргэжлийн жишиг цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” А/136 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. “Ажил, мэргэжлийн жишиг цалинг үндэслэн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлоход баримтлах журам”-ыг шинэчлэн баталж, 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

Хоёр. Батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (газар)-ийн дарга нарт, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Бодлогын хэрэгжилт, судалгааны газар (Ц.Ганцэцэг), ажил мэргэжлийн жишиг цалинтай холбоотой програм хангамжийг даалгаврын дагуу боловсруулж 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн дотор аймаг, дүүргийн хэлтсүүдэд хүргүүлэхийг Мэдээллийн технологийн төв (Г.Хүрэлбаатар), журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Д.Ганзориг)-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга (Г.Саран)-д даалгасугай.

ДАРГА



Д.ЗОРИГТ



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЖИШИГ ЦАЛИНГ ҮНДЭСЛЭН
ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ САРЫН ДУНДАЖ ХӨДӨЛМӨРИЙН
ХӨЛСИЙГ ТОДОРХОЙЛОХОД БАРИМТЛАХ ЖУРАМ
Баримт бичгийн дугаар: ЖРМ-БХСГ -2021

Баталсан: НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА  Д.ЗОРИГТ

Хянасан: БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДАРГА  Ц.ГАНЦЭЦЭГ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН  С.ЛХАГВАДОРЖ

Боловсруулсан: БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ,
СУДАЛГААНЫ ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН  Ц.ОТГОНСҮРЭН

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар ба хяналттай хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	



АГУУЛГА

1. Зорилго
2. Хамрах хүрээ
3. Хамаарах талууд
4. Баримт бичгийн хариуцагч
5. Нэр томъёоны тодорхойлолт
6. Ажил, мэргэжлийн жишиг цалин хэрэглэх
7. Ажил, мэргэжлийн жишиг цалингаар тэтгэвэр тогтоох
8. Хяналт, хариуцлага





Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/132 дугаар тушаалын хавсралт

АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ЖИШИГ ЦАЛИНГ ҮНДЭСЛЭН ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ САРЫН ДУНДАЖ ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛСИЙГ ТОДОРХОЙЛОХОД БАРИМТЛАХ ЖУРАМ

НЭГ. Зорилго

Даатгуулагчийн 1995 оноос өмнөх үеийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд ажил, мэргэжлийн жишиг цалинг үндэслэн тэтгэвэр тогтоолгох даатгуулагч, иргэний сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлох харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. Хамрах хүрээ

Энэхүү журмаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтооход Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн “Ажил, мэргэжлийн жишиг цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” А/136 тоот тушаалаар баталсан 1995 оноос өмнөх хугацааны ажил, мэргэжлийн жишиг цалинг баримтлах, тэтгэвэр тогтоох, хяналт тавих, хариуцлага хүлээлгэхтэй холбогдох харилцааг зохицуулна.

ГУРАВ. Хамаарах талууд

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар, Хяналт шалгалтын газар, Мэдээллийн технологийн төв, аймаг (нийслэл), дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс (газар), тасаг, сумын байцаагч, даатгуулагч, иргэн, тэтгэвэр авагч.

ДӨРӨВ. Баримт бичгийн хариуцагч

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газар.

ТАВ. Нэр томъёоны тодорхойлолт

5.1. “Ажил, мэргэжлийн жишиг цалин” гэж Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу нийгмийн даатгалын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан цалингийн хэмжээг ойлгоно.

5.2. “Ажил, мэргэжил” гэж тэтгэвэр авагч, даатгуулагч (иргэн)-ийн хөдөлмөрийн дэвтэр, архивын лавлагаа, шүүхийн шийдвэрт бичигдсэн ажил, албан тушаалыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар баталсан



“Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт ”ҮАМАТ”-08”-ыг баримтлан тодорхойлсныг хэлнэ.

ЗУРГАА. Ажил, мэргэжлийн жишиг цалин хэрэглэх

6.1. Дараах тохиолдолд ажил, мэргэжлийн жишиг цалинг үндэслэн даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгох сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлно:

6.1.1. Энэ журмын 2 дахь хэсэгт заасан хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон иргэний тэтгэврээ бодуулахаар сонгосон нийт онуудын эсхүл зарим саруудын 1995 оноос өмнөх хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох баримт нь архивын сан хөмрөгт байхгүй, олдохгүй байснаас шалтгаалан сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг тодорхойлохгүйгээр тэтгэврийг нь тэтгэврийн доод хэмжээгээр тогтоосон бол тэтгэвэр авагчийн хүсэлтийн дагуу ажил, мэргэжлийн жишиг цалинг баримтлан тэтгэврийг нь өөрчлөн тогтоож болно;

6.1.2. Даатгуулагч 1995 оноос өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоо сонгон шинээр тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан боловч тухайн сонгосон онуудын нийт эсхүл саруудын хөдөлмөрийн хөлсний хэмжээ нь архивын баримтаар нотлогдохгүй, архивын сан хөмрөгт байхгүй, олдохгүй байгаа бол тэдгээр саруудын хөдөлмөрийн хөлсийг ажил, мэргэжлийн жишиг цалингаар орлуулан тооцож болно.

6.2. Тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэн Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу 1995 он хүртэлх хугацааны ажилласан жилээ нөхөн тооцуулсан тохиолдолд түүний тэтгэвэр тогтоолгох хөдөлмөрийн хөлсийг тодорхойлоход ажил, мэргэжлийн жишиг цалинг хэрэглэхгүй.

6.3. Тэтгэврийг нь сарын дундаж хөдөлмөрийн хөлсийг үндэслэн тогтоосон тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг ажил, мэргэжлийн жишиг цалинг хэрэглэн өөрчлөн тогтоохгүй.


ДОЛОО. Ажил, мэргэжлийн жишиг цалингаар тэтгэвэр тогтоох

7.1. Тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэн ажил, мэргэжлийн жишиг цалингаар тэтгэвэр тогтоолгох, өөрчлөн тогтоолгох өргөдлөө оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяа нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-д бичгээр гаргана.

7.2. Тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэн нь 1995 оноос өмнөх хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох хөдөлмөрийн хөлсний баримт нь архивын сан хөмрөгт байхгүй тухай архивын байгууллагын лавлагаа авсан байна.

7.3. Энэ журмын дагуу тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоохдоо Засгийн газрын 2014 оны 15 дугаар тогтоолоор баталсан “Шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүр”-ийг баримтална.

7.4. Тэтгэвэр авагч, даатгуулагч, иргэний тэтгэврийг тогтоох, эсхүл өөрчлөн тогтоохдоо зөвхөн ажил, мэргэжлийн жишиг цалинг баримтлах бөгөөд бусад цалин






хөлсөнд хамаарах нэмэгдлийг тэтгэвэр бодоход баримтлах хөдөлмөрийн хөлсний бүрэлдэхүүнд оруулан тооцохгүй.

7.5.Тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авагчийн тэтгэврийг ажил, мэргэжлийн жишиг цалинг үндэслэн өөрчлөн тогтооход анх тогтоосон тэтгэврийн хэмжээнээс буурахаар байвал авч байсан тэтгэврийг нь үргэлжлүүлэн олгоно.

НАЙМ. Хяналт, хариуцлага

8.1.Энэхүү журмын хэрэгжилтэд нийгмийн даатгалын байгууллага болон хуулиар тогтоосон чиг үүргийн бусад байгууллага хяналт тавина.

8.2.Энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.





Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн сайд
2021 оны 09 сарын 23-ийн
өдрийн 5168 дугаарт бүтгэл.

**МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ**

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

**Ажил, мэргэжлийн жишиг цалингийн
хэмжээг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тэтгэвэр тогтооход баримтлах "Ажил, мэргэжлийн жишиг цалингийн хэмжээ"-г хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Д.Зоригт)-т үүрэг болгосугай.


3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Батжаргал)-т даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Хөдөлмөрийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/49, А/105 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



А.АРИУНЗАЯА



151201079

D: 2021 on 09 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2021 оны 09 дүгээр сарын 10-
ны өдрийн А/136 дугаар тушаалын
хавсралт



АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН
ЖИШИГ ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

(төгрөгөөр)

№	Үндсэн бүлэг	1990 он ба түүнээс өмнөх	1991 он	1992 он	1993 он	1994 он
1	Менежер	800	1600	2800	7100	12600
2	Мэргэжилтэн	650	1300	2250	5700	10200
3	Техникч болон туслах, дэд мэргэжилтэн	580	1160	2000	5060	9050
4	Контор, үйлчилгээний ажилтан	450	900	1540	3850	7850
5	Худалдаа, үйлчилгээний ажилтан	430	860	1470	3650	6500
6	Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	420	840	1430	3550	6350
7	Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	510	1020	1750	4400	7850
8	Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч	550	1100	1900	4800	8500
9	Энгийн ажил, мэргэжил	350	700	1200	2900	5150
10	Зэвсэгт хүчний ажил мэргэжил	600	1200	2080	5250	9350

...ооо...

Гарми үзэн
20 21 он 09 сар 10 өдөр